



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/255

Ховд

Г Газар эзэмших эрх шилжүүлэх тухай Г


Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэхь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын Магсаржав багийн Хаан засварын гудамжны 04 тоотод байрлах гэр, орон сууцны хашааны зориулалттай Хүрэлбаатарын Цэцэгмаа /ПП73060602/-ийн эзэмшлийн 318 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Сайнхүүгийн Гансүх /ПП91031311/-д кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 437 метр квадрат, хаягийг Баянгол 3 дугаар гудамжны 303 тоот болгон орон сууцны зориулалтаар 5 жилийн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэнд үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



02 1389
D/Zax-A/255-Da